

ӨНГӨРСӨН 2016 ОНД ШИНЭСТ ХК-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОХ БАРИЛГЫН МОДОН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭХЭЭС ГАДНА ДООРХ ГОЛ ГОЛ АЖИЛУУДЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙНА.

Өнгөрсөн 2016 онд Шинэст ХК нь үндсэн үйл ажиллагаа болох барилгын модон материалын үйлдвэрлэхээс гадна доорх гол гол ажилуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Үүнд:

Үйлдвэрлэл

1. Үйлдвэрлэлийн гол дамжлагуудын нэг болох пресс машины өндөр давтамж үүсгүүр болох эд анги эвдэрсэнээс 2 сарын үргэлжилсэн хугацаанд ажиллах боломжгүй болсон бөгөөд Хятад улсын үйлдвэрээс сэлбэг хэрэгслийг авчирч бусад цахилгааны эвдэрэлд нөлөөлсөн шалтгаануудыг олж тогтоон засварлаж ашиглалтанд оруулсан.
2. Мөн хатаалгын 4 камерын 1-ийг автомат хаалт, сэнс, хавхлагын моторууд эвдэрснийг засаж сэлбэж, мөн автомат горимд ажиллахад шаардлагатай мэдрэгч, дамжуулагчийг сольж үйл ажиллагааг нь жигдрүүлсэн. Бусад үлдсэн камеруудыг ээлж дараалан засварын графикт оруулж гүйцэтгэхээр төлөвлөв.
3. Үртэс шахагч машиныг үргэлжилүүлэн түрээслэж ажилуулан хаягдал үртэсийг шахмал түлш болгон үйлдвэрлэж, улмаар мод хатаахад түлш болгон ашиглаж зардалыг тодорхой хэмжээнд хэмнэсэн.
4. Мужаан цехийг өргөтгөж гэрийн үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд сийлбэртэй гэр 3–г хийснээс 2 ш-ийг бартераар борлуулсан.
5. Үйлдвэрийн түүхий эд тээвэрлэх зорилгоор барьж байгуулсан төмөр замыг Эрэл ХХК тасалж өөрсдийн замд ашигласныг шүүхээр шийдвэрлүүлэхээр өргөдөл гаргасан нь шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа.
6. Энэ онд наамал дүнгэн барилга 1, канад каркасан 3 байшингийн модон хийцлэлийг үйлдвэрлэж нийлүүлсэн.

Үйл ажиллагаа

1. Компанийн гадна орчинг тохижуулах зорилгоор үйлдвэрийн хашааг сунган шинээр өнгө үзэмж бүхий хашааг барьж дуусгасан.
2. Түүхий эд нөөцлөх зорилгоор Хаан банкнаас зээлсэн богино хугацаат зээлийг хугацаанд нь төлж ирсэн.
3. Конторын барилгын дээврийн засварыг бүрэн дуусгасан.
4. 2016 оны 3 сараас 5 саруудад зохиогдсон барилгын үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож компаниа сурталчилсан.
5. Компанийн гүйцэтгэ худирдлагууд Хөдөлмөрийн яамнаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Бизнес удирдлага сургалтанд хамрагдсан.

Дүгнэлт

2016 онд Шинэст ХК-ны үйл ажиллагаанд тодорхой хэлбэрээр ахиц дэвшил гарсан боловч дараах үндсэн зорилгууддаа хүрч ажиллаж чадаагүй.

Үүнд:

- Төлөвлөсөн борлуулалтын оролго биелэгдээгүй
- үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- ажилчдын цалинтэтгэмжийг нэмэх
- үйлдвэрийн барилгын дээврийн засвар үйлчилгээг хийх
- гадна болон үйлдвэрийн доторх сантехникийн шугамын шинэчлэл

Шалтгаан нь :

Засгийн газрын 2013 оны 230-р тогтоолоор импортоор оруулж байгаа хэрэглээний бөөрөнхий мод, гуалин, модон зүсмэл материал, мөн стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг НӨАТ-с чөлөөлсөн.

Төгрөгийн ханшны сулралт ОХУ-с бэлтгэдэг түүхий эдийн үнэд нөлөөлж, мөн их хэмжээний модон рейк ОХУ-с импортлогдож дотоодын зах зээлд манай компанийн борлуулдаг үнээс даруй 30 – 40 хувиар бага үнээр борлуулагдсан. Дотоодын мод бэлтгэл багасаж, түүхий эдийн үнийн өсөлт 1м3 банз 350 000 төгрөг хүртэл нэмэгдсэн, түүхий эд бэлтгэлийг төрөл бүрийн эх үүсвэрээс янз бүрийнч анартай, хэмжээтэйгээр худалдан авч үйлдвэрлэлд ашигласан нь үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний гарцыг багасгаж, хаягдал ихэссэн нь борлуулалтаас олохорлогод өндөр хувиар нөлөөлсөн.

Мөн зарим тохиолдолд түүхий эдийн хомсдол бий болж үйлдвэрийг зогсоох хүртэл арга хэмжээ авсан нь үйл ажиллагааг ихээхэн доголдуулсан.

Борлуулалтын орлого байгууллагын сарын зардалыг дөнгөж нөхөхүйц зарим өвлийн саруудад зээл болон бусад эх үүсвэрээр нөхөж байгаа нь үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах дорвитой шийдэлийг эрэлхийлэх талаар хувьцаа эзэмшигчдийн хуралаар хэлэцүүлэх шаардлагатай байна.

Цаашид яаралтай авахарга хэмжээнүүд:

- Үйлдвэр болон албан конторын барилгын дээврийн засварын ажлыг маш яаралтай хийх
- Түүхий эд бэлтгэх найдвартай эх сурвалжтай болохтүүхий эд худалдан авах эргэлтийн хөрөнгийн төвлөрөл үүсгэх.

Иймд дээрх асуудлыг хувьцаа эзэмшигчидийн ээлжит хурлаар хэлэлцэх санал оруулж байна.

Ä-ÉÖÝÒÃÝÕ ÇÀÕÈÐÀË /Ä. ÁÀÕÄÀÌÄÝÌÁÝÐÝË/

